



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/46

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Стандарт хэмжил зүйн хэлтсийн хуучин барилга байгууламжийг “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар”-т түр хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Хурцгэрэл (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Б.Нансалмаа (Орон нутгийн өмчийн газрын хууль, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн)

Т.Мөнхнасан (Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Ц.Бат-Орших (Алтай хотын тохижилт үйлчилгээний газар аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга)

2. Стандарт хэмжил зүйн хэлтсийн хуучин барилга байгууламжийг төрийн өмчит хуулийн этгээдээс орон нутгийн өмчид шилжүүлэх хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт яаралтай хүргүүлж шийдвэрүүлж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т үүрэг болгосугай.

3. Төрийн өмчийг Улсын Их Хурлаар шийдвэрлэх хүртэл хугацаанд “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар”-т Стандарт хэмжилзүйн хэлтсийн хуучин барилга байгууламжийг түр хүлээлцүүлэх ажлын хэсэг (Г.Хурцгэрэл)-т, Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ

